

**БОГД БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2021 ОНЫ ХАГАС  
ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

Миний бие Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс томилогдон ажилласнаас хойш өдгөө 7 дох жилдээ хараат бус гишүүний чиг үүргээ биелүүлэн ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Цалин хөлс, нэр дэвших хорооны гишүүнээр томилогдон ажилласан байсан бөгөөд 2021 оны 2 дугаар сарын 15-нд ТУЗ-д шинэ гишүүн томилох асуудлаар нэг удаа хуралдаж саналаа өгч хуралд оролцсон байна. Тайлант хугацаанд Аудитын хороог 3 удаа хуралдуулж, аудитын тайлан болон бусад асуудлыг хэлэлцсэн. Дотоод аудитын газраас бэлтгэсэн аудитын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, чиглэл өгч ажилласан. Дотоод аудитын 2021 оны төлөвлөгөөг эрсдэлд суурилсан аргачлал руу шилжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн ба үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, орон тоо, аудитын төлөвлөгөөг хянаж батлуулсан. 2021 онд Дотоод аудитын газрын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх чиглэлд анхаарч, тус газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд санал өгсөн.

2021 оны 05 сарын 20-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг бүтэц, бүрэлдхүүнд холбогдох журамд өөрчлөлт оруулах тухай 21/59 тоот тогтоолоор Цалин хөлс, нэр дэвших хороог Урамшууллын хороо болон Хүний нөөцийн хороо гэж салгасан байгаа. Үүнтэй холботойгоор Хүний нөөцийн хорооны даргаар томилогдон ажиллаж байгаа болно.

Энэ хугацаанд ТУЗ-ийн шинээр томилогдох гишүүн Эллиот Аукланд Рованы албан ёсны зөвшөөрөл Монгол банкнаас ирсэн тул 6 сарын 23-ны өдрийн Хүний нөөцийн хороо хуралдаж ТУЗ-ийн шинэ гишүүнийг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Эрсдэлийн хороонд гишүүнээр томилох саналыг ХНХорооноос гаргуулах ТУЗ-ийн тогтоолоор батлуулсан болно.

Хагас жилийн хугацаанд ТУЗ-оос зарлагдсан бүх хуралд зайнаас оролцон саналаа өгч ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ 100% биелүүлж идэвхтэй ажилласан болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Ж.Нарантуяа